



## ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 15 өдөр

Дугаар А/328

Эрдэнэт

### Хөрөнгө гаргах тухай

“Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 /а/, 29.1.6 /г/, 29,2, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит IV хуралдааны 01 дүгээр тогтоолоор батлагдсан аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй үйлдвэрлэл эрхлэгчид, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас зээл авсан, зээл авахаар хүсэлт ирүүлсэн өрхийн болон жижиг дунд үйлдвэрлэгчдийн чадавхийг сайжруулах сургалт зохион байгуулахад шаардлагатай 6000000 /зургаан сая/, Ил задгай худалдаа эрхлэгчдийн үйл ажиллагааг зохицуулах зорилтын хүрээнд Эрүүл ахуйн тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль, холбогдох дүрэм, журмыг сурталчилах ажлыг зохион байгуулахад 300000 /гурван зуун мянга/ төгрөг, “Худалдаа үйлчилгээ аялал жуулчлалын соёл аян”-ыг хэрэгжүүлэх зардалд 1080000 /нэг сая наян мянга/ төгрөг, нийт 7380000 /долоон сая гурван зуун наян мянга / төгрөгийг хавсралтаар баталж Засаг даргын бусад зардлын аймгийн жижиг дунд бизнес эрхлэгч, аж ахуйн нэгж байгууллагуудыг олон нийтэд таниулан сурталчилан урамшуулах зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

Хоёр. Захирамжийн хэрэгжилтийг ханган, дээрх үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /н. Баяржаргал/-т үүрэг болгосугай.



ЗАСАГ ДАРГА

Д. БАТЛУТ

D:(Zahiramj) A-4 doc  
0200001528

Аймгийн Засаг даргын 2017 оны 06 дугаар сарын 15  
 өдрийн 328 дугаар захирамжийн хавсралт

**ЖДҮ нарт зориулсан сургалтын төсөв**

Сургалтын сэдэв: Зах зээл ба маркетинг						
№	Зориулалт	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Үнэ	Нийт	Тайлбар
1	Багшийн хөлс	8	цаг	150,000	1,200,000	45 минутыг 1 цагт тооцож хөлс олгоно.
2	Багшийн тээврийн зардал	2	удаа	33,000	66,000	УБ-ОР-УБ
3	Телевиз зардал	1	удаа	150,000	150,000	Бичлэг хийж түүнийгээ эмхэтгэн ТВ цацахаар бэлдэж өгнө.
4	Сургалтын өрөөний түрээс	8	цаг	60,000	480,000	
5	Кофе завсарлага	65	хүн	3,500	227,500	Бургер кофе бэлтгэнэ.
6	Гарын авлага	60	хүн	3,500	210,000	Оролцогчдод гарын авлага олшруулна
7	Өдрийн хоол	60	хүн	9,000	540,000	
8	Сургалтын хэрэглэгдэхүүн	1	хүн	51,500	51,500	
9	Анонс	15	м2	5,000	75,000	
<b>дүн</b>					<b>3,000,000</b>	
Сургалтын сэдэв: Бизнесийн харилцаа						
№	Зориулалт	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Үнэ	Нийт	Тайлбар
1	Багшийн хөлс	6	цаг	150,000	900,000	45 минутыг 1 цагт тооцож хөлс олгоно.
2	Телевиз зардал	1	удаа	150,000	150,000	Бичлэг хийж түүнийгээ эмхэтгэн ТВ цацахаар бэлдэж өгнө.
3	Сургалтын өрөөний түрээс	6	цаг	60,000	360,000	
4	Кофе завсарлага	65	хүн	3,500	227,500	Бургер кофе бэлтгэнэ.
5	Анонс	14.5	м2	5,000	72,500	
6	Сургалтын хэрэглэгдэхүүн	1	удаа	80,000	80,000	
7	Гарын авлага	60	хүн	3,500	210,000	Оролцогчдод гарын авлага олшруулна.
<b>Дүн</b>					<b>2,000,000</b>	
Сургалтын сэдэв: Санхүүгийн боловсрол						
№	Зориулалт	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Үнэ	Нийт	Тайлбар
1	Багшийн хөлс	6	цаг	60000	360000	
3	Сургалтын өрөөний түрээс	6	цаг	60,000	360000	
4	Кофе завсарлага	30	хүн	5,500	165000	Бургер, пирожин кофе бэлтгэнэ.
5	Анонс	8	м2	5,000	40000	
6	Гарын авлага	30	хүн	2,500	75,000	Оролцогчдод гарын авлага олшруулна.
<b>Дүн</b>					<b>1,000,000</b>	
<b>Нийт дүн</b>					<b>6,000,000</b>	

Аймгийн Засаг даргын 2017 оны 06 дугаар сарын 15 өдрийн 328 дугаар захирамжийн хавсралт

ОРХОН АЙМГИЙН БРЭНД БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ СУРТАЛЧЛАН ТАНИУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

№	Зориулалт	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нэгж үнэ	Нийт
1	Телевизийн шторк хийлгэх / 1 минут 100.0 мян 6 шторк хийлгэх/ цацацах	6	минут	160,000	960,000
2	Сурталчилгааны фостер хийлгэх / 6 төрөл 1 фостер 20000/	6	ш	20,000	120,000
3	Ил задгай худалдааг зохицуулахад хууль сурталчилах телевизийн шторк	2	минут	100,000	200,000
4	Ил задгай худалдааг зохицуулахад хууль сурталчилах тараах материал	100	ш	1,000	100,000
	<b>Нийт дүн</b>				<b>1,380,000</b>